БАТЛАВ.
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д.БАЯНДҮҮРЭН

УХА0306

БАТЛАВ.
“БЕСТ КОЛОР ИНТЕРНЭШНЛ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

Н. АЛДАР

БЕСТ КОЛОР ИНТЕРНЭШНЛ ХХК

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2016 оны 9 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар ОНС-06

Улаанбаатар
хот

Нэг. ***Нийтлэг үндэслэл***

1.1. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулиар хэрэглэгдэх Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл, мэдээллийн технологийн даамлын гарын авлага хэвлүүлэх ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор захиалагч Сонгуулийн Ерөнхий Хороо /цаашид Захиалагч гэнэ/-г төлөөлж Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, эмхэтгэлийн эх бэлтэх, хэвлэх ажлыг гүйцэтгэгч “Бест колор Интернэшнл” ХХК /цаашид гүйцэтгэгч гэнэ/-ийг төлөөлж менежер Б.Намчинсүрэн нар харилцан тохиролцож, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.2. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл, даамлын гарын авлагыг чанар үзэмжтэй, алдаагүй хэвлэж, гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх ажлуудыг гүйцэтгэгч тал хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. ***Захиалагчийн эрх, үүрэг***

2.1. Захиалагч тал хэвлүүлэх материалын эх текстийг 2016 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр өгөх ба хэвлэлийн загвар, тавигдах шаардлагыг Гүйцэтгэгчид өгнө.

2.2. Хууль тогтоомжийн эмхэтгэл, гарын авлагын эх бэлтгэх, түүнийг хэвлэх ажилд Захиалагчийн зүгээс хяналт тавьж ажиллана.

2.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүн гэрээний шаардлагад нийцээгүй тохиолдолд ажил гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг дахин гүйцэтгүүлнэ.

2.4. Гүйцэтгэсэн ажлын төлбөрийг ажил хүлээж авсан баримт үйлдсэний дараа саадгүй гүйцэтгэнэ.

Гурав. ***Гүйцэтгэгчийн эрх, үүрэг***

3.1. Хэвлүүлэх материалын эх бэлтгэх, хэвлэх ажлын талаар Захиалагчид танилцуулан, хэвлэх зөвшөөрөл авна.

3.2. Эмхэтгэлийг А5 хэмжээтэй, нийт 1,500 ширхэг, гарын авлагыг В6 хэмжээтэй, нийт 2700 ширхэгийг хэвлэн 9 дүгээр сарын 10-ны өдөрт багтаан 100 ширхэгээр багцлан боож, баглаа боодлыг аймаг, сумдад хүргэхэд задарч, гэмтэхгүй байхаар тооцон хийж, баглаа боодлын гадна талд хэвлэмэл материалын нэр, тоо, ширхэгийг бичиж Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.3. Хэвлэлд бэлэн болсон эх файлыг Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.4. Ажил гүйцэтгэх явц, чанар, хугацаа, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.5. Гүйцэтгэгч нь захиалагчаас өгсөн эх загвараас өөрөөр болон алдаатай хэвлэхгүй.

3.6. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 19 дүгээр хавсралтын дагуу гаргасан мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хорооны www.gec.gov.mn цахим хуудаст байршуулж, Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.

Дөрөв. ***Төлбөр тооцоо***

4.1. Хууль тогтоомжийн эмхэтгэл хэвлэх гэрээний үнэ болох 8,256,600 төгрөгийг захиалгат ажлаа хүлээн аваад ажлын 3 хоногт багтаан "Бест колор интернэшнл" ХХК-ний Голомт банкны 2201044083 тоот дансанд шилжүүлнэ. Регистрийн дугаар: 2692392

№	Бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Хууль тогтоомжийн эмхэтгэл, А5	1,500	1800	2,700,000
2	Даамлын гарын авлага, В6	2700	1780	4,806,000
	ДҮН			7,506,000
	НӨАТ 10%			750,600
	НИЙТ ДҮН			**8,256,600**

4.2. Гэрээний үнийн дүнд НӨАТ орсон болно.

Тав. ***Бусад зүйл***

5.1. Захиалагчийн буруутай үйлдлээс шалтгаалж загвар, агуулгыг өөрчилсөн зэргээс үүдэн гарах хариуцлагыг Захиалагч өөрөө хүлээнэ.

5.2. Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх хугацааг хожимдуулсан, чанарын гологдол, алдаа гаргасан, гэрээний нөхцлийн дагуу гүйцэтгээгүй зэрэг шалтгаанаас учирсан хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.

5.3. Энэхүү гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

5.4. Маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба эс тохиролцвол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Сонгуулийн Ерөнхий Хорооны
Мэдээлэл, судалгаа, арга зүйн
хэлтсийн дарга

Б.ОЮУМАА

Хаяг: Улаанбаатар-38
Ж.Самбуугийн гудамж-11
3Г-ын XI байр
байр,
Сонгуулийн ерөнхий хороо
Утас: 51-263602, 9909-1893
oyumaa@gec.gov.mn

"Бест колор интернэшнл" ХХК-ийн
менежер

Б. НАМЧИНСҮРЭН

Хаяг: Улаанбаатар
Сүхбаатар дүүрэг, Жамьян
гүний гудамж, "BCI" ХХК-ийн
байр,

Утас: 11-319032, 88106553
bci@bci.mn